



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/103

Номгон

“Энхтайваны төлөө ус” уриан дор “Дэлхийн 7
усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 2/7 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.4, 5.2, 2023 оны 17/59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 104 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Энхтайваны төлөө ус” уриан дор “Дэлхийн усны өдөр”-ийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.


2. “Дэлхийн усны өдөр”-ийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4. “Дэлхийн усны өдөр”-ийн хүрээнд усны нөөцийн хомстол бохирдлоос хамгаалах, усны чанар, зүй зохистой хэрэглээг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулж, экологийн мэдлэг хандлага, төлөвшлийг олгох олон талт ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайлан, баримт бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны дотор Төрийн архивын тасагт хүлээлгэн өгч, танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Ням-Очир)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар) -т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

624010184

Аймгийн Засаг даргын 2023 оны 9 дугаар сарын 23-ны
өдрийн 1103 дугаар захирамжийн хавсралт



**“ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР”-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

| | | |
|------------------------------------|--|--|
| Ажлын хэсгийн ахлагч Гишүүд: | Б.Ням-очир Ч.Оюунчимэг Б.Намуун Б.Зүгдоржав Д.Цэцэнхүү М.Өлзийхишиг Л.Энхтогтох Х.Сонинбаяр Э.Сэмбэсүрэн | Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан мэргэжилтэн Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Бөөнцагаан -Орог нуурын сав газрын захиргааны Усны чанар, экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа, орчны бүс хариуцсан мэргэжилтэн “Сум дундын ойн анги” ОНӨААТҮГ газрын ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга | Ж.Баасансүрэн | Бөөнцагаан -Орог нуурын сав газрын захиргааны Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, сургалт, архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн |

оОо